УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

# “УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН” ОНӨТҮГ-ЫН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

**“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН” ОНӨТҮГ-ЫН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТ**

2022 оны 06 дугаар сарын 22

| Д/д | Нийслэлийн засаг дарга бөгөөд Хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2.6.2.3/-ийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв (мян.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1.1. “Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагааг боловсрол, түүх соёлын чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ.” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1.1.1. | Музейн барилгыг түүхэн байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөлийн шинэ барилга барих санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ. | - | Хүргүүлсэн саналын тоо | Сэргээн засварлалтын зураг боловсруулсан. | 1 | Музейн барилгыг түүхэн байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөлийн шинэ барилга барих санал хүргүүлж, шийдвэрлүүлэх ажлын хүрээнд: 1.Ажилтнуудын албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл 120,153,400₮<br>2. музейн камер, дохиоллын системийн тоног төхөөрөмж 32,095,580₮<br>3. музейн цахилгаан болон барилгын урсгал засвар 67,110,680₮ нийт-219,359,660₮ зардлын төсөвтэйгөөр нийслэлийн худалдан авах ажиллагааны газартай хамтран улаанбаатар хотын музейн барилгын засвар, техник хэрэгсэл нийлүүлэх тухай 202202289 дугаартай тендер 30 хоногийн хугацаатай зарлагдаж “Онь тэнгэрийн бичиг ХХК” шалгарч засварын ажил хийгдэж дууссан ба тавилга эд хогшил, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | техник тоног төхөөрөмжийг захиалаад БНХАУ-н хил гааль хаалттай байгаагаас шалтгаалан 7-р сард орж ирэхээр төлөвлөгдөж байна.<br>- НЗДТГ-ын ХБТХ-ээс явуулсан бичгийн дагуу Нийслэлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд “Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-ийн санал, төсөл, арга хэмжээ холбогдох мэдээллийг https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системд оруулан хавсралт маягтын дагуу боловсруулан албан бичиг болон цахим хэлбэрээр НЗДТГ-ын ХБТХ-д илгээж ажилласан. Энэхүү ажлын хүрээнд Улаанбаатар хотын музей нь "Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулах төлөвлөгөөний төсөлд тусгах төсөл, арга хэмжээний саналаа НЗДТГ, НСУГ-т 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 77, 78 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. | |
| 1.1.2. | Музейн дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ. | - | Бүтэц, орон тоог баталсан захирамж | - | 1 | Музейн дүрмийг ажлын хэсэг шинэчлэн боловсруулж, төслийг захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцүүлсэн. НИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн, батлуулахаар дүрмийн төслийг “Улаанбаатар хотын музейн дүрэм шинэчлэн батлуулах тухай тайлбарын хамт хүргүүлж Төрийн захиргаа | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удирдлагын хэлтэсд хянагдах шатандаа явж байна. | |
| 1.2. “Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1.2.1. | Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, боловсрол, соёлын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | - | арга хэмжээний тоо<br>Хамруулсан иргэдийн тоо | 4<br>100 | 4<br>100 | -Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан. Музейгээс 2022-2025 онд хэрэгжүүлэх урт хугацааны “Бидний Баатар хот” боловсролын хөтөлбөрийг хэлэлцэж, музейн захирлын 2022 оны 02 дугаар сарын 07-ны А/11 дүгээр тушаалаар батлуулсан болно.<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас сан хөмрөг дэх үзмэрүүдээр<br>-Их хүрээ (одоогийн Улаанбаатар) Монгол Улсын нийслэл хот болж, Нийслэл хүрээ хэмээн нэрлэгдсэний 110 жилийн ойд зориулан “Нийслэл хүрээ 110” жил үзэсгэлэнг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Архивын газартай хамтран Монголын үндэсний музейн түр үзэсгэлэнгийн танхимд 2022 оны 02 дугаар сарын 09-23нд дэлгэгдэж нийтийн хүртээл болов.<br>-Нийслэл хүрээ 110 жилийн ойд зориулан “Хуучин хот” сэдэвчилсэн үзэсгэлэнг 2022 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн музейн үзүүллэгийн танхимд гаргасан.<br>-2022 оны 05 дугаар сарын 18-нд Олон улсын музейн өдөрт зориулж “Хөрөг” сан хөмрөгийн сэдэвчилсэн үзэсгэлэнг музейн танхимд гаргаж дэглэн үзэгчдийн хүртээл болгов. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -2022 оны 05-р сарын 26-нд Мишээл экспо дээр Рой Чапмен Эндрюсийн 1922-1923 онд авсан гэрэл зургийн үзэсгэлэн гаргав.<br>-05-р сарын 27, 05-р сарын 28-нд “Номын баяр”, “Авто машингүй өдөр”-өдрүүдэд музейгээс гаргасан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдхүүнийг сурталчилах ажлыг зохион байгуулав.<br>-Сонгинохайрхан дүүргийн иргэдэд Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаа, хотын түүх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор тус дүүргийн Соёлын ордонтой хамтран 54 дүгээр сургууль дээр 2022.06.15-17-ний өдрүүдэд “Улаанбаатар хотын музейн нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулав. Уг арга хэмжээний хүрээнд “Нийслэл хүрээнээс Улаанбаатар хот” гэрэл зургийн үзэсгэлэн, “Марчаахай Улаанбаатар хотын түүхээр аялсан нь” гурван цуврал анимейшн, “Хотын түүхийг хоёр минутад” цуврал видео контент, “Бидний баатар хот” боловсролын ажил, Өндөр Гонгорын хэвлэмэл зурагтай гэрэл зураг авахуулах зэрэг үйлчилгээ үзүүлэв. Уг арга хэмжээнд нийт 512 хүн хамрагдав.<br>-Музейн цахим хуудаст оруулах “Чин ван Ханддоржийн өргөө”, “Анхны европ хийцийн хоёр давхар барилга”-ын түүхийг бичив.<br>-Түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой сэдэвчилсэн үзэсгэлэн гаргах, музейн цахим хуудсаар дамжуулан музейгээс зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулах ажлыг сурталчилах, Улаанбаатар хотын түүхийн чиглэлээр бяцхан ном, хөлөгт тоглоом хийх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллаж байна. | |

2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Музейн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах хууль, Монгол улсын стандарт MNS 5634:2006 - "*Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага*", НИТХТ-ийн тогтоолоор батлагдсан УБХМузейн дүрмийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ | | | | | | | |
| 2.1. "Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулна" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.1.1. | Байгууллага, иргэдийн гар дээр байгаа үзмэр, эд өлгийн зүйлийн хайгуул, судалгаа хийж, бүртгэл хөтөлнө. | - | Бүртгэгдсэн үзмэр, эд өлгийн зүйлийн тоо | 5 | 10 | Хувь хүний гар дээр байгаа музейд худалдах саналтай 4 дэсийн 7 ширхэг эд өлгийн зүйлийг бүртгэлжүүлж ач холбогдлын хувьд музейн үзмэр цуглуулгын бодлоготой нийцэх талаар эрдэм шинжилгээ судалгааны ажил хийгдэж байгаа. Мөн үзмэр худалдан авах санхүүжилт 3 дугаар улиралд орох тул санал болгосон эд өлгийн зүйл бүртгэн авах ажил хойшлогдож байна. | 100 |
| 2.1.2. | Музейн арга зүйн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, музейн үндсэн үйл ажиллагааны холбогдолтой асуудлуудыг хэлэлцэнэ. | - | Зөвлөлийн хуралдсан тоо<br>Хэлэлцсэн асуудлын тоо | 1<br>2 | 1<br>2 | -Музейн арга зүйн зөвлөлийн хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж, Музейн байнгын үзүүллэгийн танхимын дэлгэрэнгүй тайлбарыг хэлэлцэж, музейн захирлын 2022 оны 02 дугээр сарын 07-ны А/10 дугаар тушуул болон Музейгээс 2022-2025 онд хэрэгжүүлэх урт хугацааны "Бидний Баатар хот" боловсролын хөтөлбөрийг хэлэлцэж, музейн захирлын 2022 оны 02 дугаар сарын 07-ны А/11 дүгээр тушаалаар батлуулсан болно.<br>-Музейн арга зүйн зөвлөлийн хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 27-нд зохион байгуулж, музейн сан хөмрөгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хадгалалт, хамгаалалт хийх үзмэрийн жагсаалт, авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэж, шийдвэрлэсэн. | |
| 2.1.3. | Музейн үзмэр цуглуулгын бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | -Улаанбаатар хотын музейн үзмэр, цуглуулгын менежментийн бодлогын баримт бичиг боловсруулах талаар музейн захирлын 2022 оны 05 дугаар сарын 09-ний “Ажлын хэсэг байгуулах тухай” А/36 дугаар тушаал батлуулж, “Музейн үзмэр цуглуулгын менежментийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. | 100 |
| 2.1.4. | Музейд үзмэр авах журмыг боловсруулан батлуулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | -“Музейн үзмэр авах журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Монголын Үндэсний музейн арга зүйчдээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, хууль, журамд нийцүүлэн “Музейн үзмэр авах зөвлөл”-ийг “Сан хөмрөгийн зөвлөл” болгон шинэчлэн байгуулж, “Музейд үзмэр авах журам”-ыг “Сан хөмрөгийн зөвлөлийн журам” болгон шинэчлэн боловсруулж, музейн Захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлийн 2022 оны 04 дүгээр хурлаар хэлэлцэж, музейн захирлын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар батлуулав. | 100 |
| 2.4. “Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.4.1. | Соёлын өвийн бүртгэлийн маягт №2-оор бүртгэгдсэн музейн үзмэр, эд өлгийн зүйлийг төрөлжүүлэн архивлана. | - | Цаасан хэлбэрээр архивласан үзмэрийн тоо | 200 | 200 | Уран зургийн төрлийн үзмэрээс 40 ширхэг, мөнгөн тэмдэгтийн төрлөөс 90 ширхэг, угсаатан зүйн төрлөөс 20 ширхэг, баримт бичгийн төрлөөс 30 ширхэг, сийлбэр, гар урлалын төрлийн 20 ширхэг нийт 200 ширхэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзмэр, эд өлгийн зүйлийг төрөлжүүлэн архивлах ажлыг хийлээ. | |
| 2.2.2. | RCH бүртгэлийн программд үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн оруулах ажлыг зохион байгуулна. | - | Бүртгэлийн программд оруулсан үзмэрийн тоо | 150 | 150 | Соёлыг өвийн бүртгэн баримтжуулах зааврын дагуу "RCH" программд 80 дэсийн 150 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн оруулсан. | 100 |
| 2.2.3. | Сан хөмрөг дэх гэрэл зургийн төрлийн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, гэрэл зургийг судлан шинжлэх, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Цахим хэлбэрт шилжүүлсэн үзмэрийн тоо | - | 50 | Сан хөмрөгийн үзмэрийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд гэрэл зургийн /альбом/ төрлийн 25 дэсийн 1263 ширхэг үзмэрийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж хуудас бүрд шүлтгүй цаасаар хамгаалалт хийж гэрэл зургийн наалдахаас урдчилан сэргийлсэн. Мөн гэрэл зургийн төрлийн 52 дэсийн 443 ширхэг үзмэр тус бүрт хамгаалалтын шүлтгүй цаасаар уут хийж хадгалалт хамгаалалтыг сайжруулж бүртгэн баримтжуулах зааврын дагуу үзмэрийн нэр, хувийн дугаар, дэс дугаарыг тэмдэглэсэн.<br>Тайлант хугацаанд нийт 77 дэсийн 1706 ширхэг гэрэл зургийн төрлийн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулсан байна. | 100 |
| 2.2.4. | Музейн бүртгэл мэдээллийн санг архивын журам, зааврын дагуу ангилан төрөлжүүлж, мэдээлэл, лавлагааны сан бий | - | Мэдээлэл лавлагааны сантай болсон байна. | - | 1 | Байгууллагын бүртгэл мэдээллийн санд 2021 онд үүссэн үзмэр, эд өлгийн зүйлийн хөдөлгөөний акт болон бүртгэлттэй холбогдолтой гурван төрлийн бичиг баримтаар бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийлээ. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болгох ажлыг зохион байгуулна. | | | | | 1.2021 онд шинээр музейд авсан үзмэр, эд өлгийн зүйлийн холбогдолтой баримт бичгийн хавтас<br>2.Үзмэрийн хөдөлгөөний холбогдолтой хавтас<br>3. 2021 оны байгууллагын сан хөмрөгийн тооллого явуулсан акт | |
| 2.2.5. | Музейн сан хөмрөгийн үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулж, эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулна. | 804.2 | Хадгалалтын нөхцөлийг дээшлүүлсэн үзмэрийн тоо | 70 | 115 | Шинж байдлын үзлэгийн мөрөөр сан хөмрөгийн үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах, эрсдлээс хамгаалах ажлын хүрээнд баримт бичгийн төрлийн 12 дэсийн 33 ширхэг үзмэрийн хадгалалтын байдлыг сайжруулж үзмэр тус бүрд шүлтгүй цаасаар хамгаалалтын сав хийсэн. Мөн музейн бүртгэн баримтжуулах зааврын дагуу баримт бичгийн төрлийн 79 дэсийн 82 ширхэг үзмэр хадгалагдаж буй 10 хайрцагт үзмэрийн товьёгжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Уран зургийн төрлийн овор хэмжээ их үзмэрийг зөөж тээвэрлэх, тоос шорооноос хамгаалах зориулалтаар 120х100 хэмжээтэй 2 ширхэг, 90х90 хэмжээтэй 1 ширхэг ямбуу даавуун хамгаалах уут хийсэн. Энэ нь уран зураг музейн байрнаас өөр үзэсгэлэнд гархад үзмэрийг зөөж тээвэрлэхэд зориулсан. Тайлант хугацаанд 91 дэсийн 115 дэсийн үзмэр эд өлгийн зүйлийг эрсдлээс хамгаалах ажил хийгдсэнбайна.<br>Үзмэртэй харьцах бээлий 220,000 төгрөгөөр авсан. "Монгол улсын стандарт" гар урлал болон урлагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5634/2006 12.9.5 т заасны дагуу сан хөмрөгийн өрөөнд мэргэжлийн байгууллагаар хортон шавьж, мэрэгчийн ариутгал, музейн үзмэр болон сан хөмрөгийн цэвэрлэгээний зардалд 584,200 төгрөгийг тус тус зарцуулагдсан байна. | |
| 2.2.6. | Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах | | Тооллого хийсэн тоо | - | 2 | Музейн захирлын 2022 оны 01 сарын 12-ний өдрийн А/02 тушаалын дагуу сан хөмрөгийн байгууллагын тооллогыг 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 21- ний өдрийн хооронд зохион байгуулсан. Музейн сан хөмрөгийн байгууллагын тооллого хүрээнд 783 дэсийн 3428 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг нэг бүрчлэн тулган үзэж тоолсон. 1 дэсийн 1 ширхэг үзмэр Соёлын өвийн үндэсний төвд сэргээн засварлалтанд байгаа учраас энэ удаагийн тоологонд хамрагдаагүй. Тооллого төлөвлөсөн хугацааны дагуу явагдаж дууссан.<br>-Музейн захирлын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Эд хөрөнгийн улсын тооллогын комисс байгуулах тухай” А/28 дугаар тушаалаар Музейн түүх, соёлын дурсгалт зүйлсийн бүртгэлд байгаа 794 дэсийн 3429 ширхэг 496,439,319 төгрөгийн үзмэр, эд өлгийн зүйл, 14 дэсийн 29 ширхэг 4,792,000.04 төгрөгийн үзмэрийн туслах хэрэглэгдэхүүн, нийт 808 нэр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрлийн 3458 ширхэг 501,231,319.04 төгрөгийн үнэ бүхий үзмэр, эд өлгийн зүйлсийг нэг бүрчлэн нүдээр үзэж тоолсон бөгөөд тооллогын цахим хуудсанд нэг бүрчлэн байршуулсан. Бүртгэлд тусгагдсан хөрөнгийн төрөл, хадгалалт хамгаалалтын хяналтын байгууллагын төрөл зэргээр үзмэр, эд өлгийн зүйлийн төлөв байдлын зэргийг тодорхойлсон. | |
| 2.2.7. | Музейн барилга, сан хөмрөг, үзмэрийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллана. | - | Аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан тоо | 1 | 3 | Музейн үзүүллэгийн танхимд дэглэгдсэн үзмэрийн хадгалалт, аюулгүй байдалд хяналт хуваарийн дагуу музейн тайлбарлагч Д.Дэлгэрмөрөнгийн үзлэг, бүртгэлд хуваарь гарган хуваарийн дагуу хяналт тавьж ажиллаж байна. Музейн барилгын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд "Түүхэн дурсгалт барилгын ойр орчимд стандартын бус татсан цахилгааны, холбооны, кабелийн шугам, сүлжээ, утаснуудыг цэгцлэх" талаар 2021 онд 23 албан байгууллагатай хамтран ажиллаж, цахилгааны утас болон холбооны утаснуудыг цэгцлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд тус ажлаас хэрэгжих шатандаа байгаа "Кабелийн шугам, сүлжээг салгуулах" чиглэлээр УБЦТС-аас өгсөн зөвлөмжийн дагуу тайлант хугацаанд "Скайтель, Юнитель, Мобиком, Ситинет, Жи-мобайл, Скайнетворкс зэрэг 6 байгууллагатай холбогдон хүсэлт явуулж, албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд 4 байгууллагаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | музейд албан ёсны хариуг ирүүлсэн болно. Музейн барилгын ойр орчимд татсан кабелийн шугам, сүлжээний эзэн холбогдогч тодорхой болоогүй тул музейн Захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газарт "Эзэн холбогдогчийг тодорхойлох, хариу арга хэмжээ авахуулах" талаар албан бичгээр хүсэлтийг хүргүүлэв. Мөн "Иргэн, үйлчлүүлэгчид барилгын ойр орчимд баримтлах дэг"-ийг боловсруулан захирлын А/23 дугаар тушаалаар батлуулав. | |
| 2.3. "Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүллэгийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгоно" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.3.1. | Шинээр баригдах музейн үзүүллэгийн үзэл баримтлал, сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулж дууснa. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 5 | Шинээр баригдах музейн үзүүллэгийн үзэл баримтлал, сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд нийт үзмэрийн тоо баримтын судалгааг хийсэн бөгөөд үзмэрийн агуулгын үечлэл ба төрөл, үзмэрт буй баримтын хэл ба үечлэлийн байдал, үзмэрийн бүтээсэн үе ба агуулгын үечлэл, үзмэрийн бүтээсэн үе ба төрөл, үзмэр хуулбар эсэх, шинээр баригдах музейд тавигдах үзмэрүүдийн жагсаалт, хананд, тавиурт, витринд тавигдах үзмэрийн жагсаалтуудыг гаргаж дууссан. | 100 |
| 2.3.2. | Монгол Улсын анхны Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан "Гоожингийн өндөр" | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | - | Музейн захирлын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан "Гоожингийн өндөр" хэмээх хоёр | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэмээх түүхэн дурсгалт хоёр давхар барилгад музей байгуулах үзэл баримтлал, сэдэвчилсэн төлөвлөгөө боловсруулан гаргана. | | | |
| 2.3.3. | Музейн үйлчилгээний стандарт боловсруулан батлуулна. | - | Боловсуулсан баримт бичгийн тоо | - |

| | | |
|---|---|---|
| | давхар барилгын шинэ үзүүллэгийн танхимын үзэл баримтлал, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн ахлагчаар Г.Очбаяр, гишүүдэд О.Одсүрэн, Э.Гэрэлмаа, түүхч, судлаач Г.Дашням (зөвшилцсөнөөр) нарыг томилсон. Гоожингийн өндөр хэмээх түүхэн дурсгалт хоёр давхар барилгыг музейн чиглэлээр ажиллуулах ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулан батлуулсан. Тайлант хугацаанд Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан барилгын түүхийг архивын баримт, түүхийн судалгааны ном бүтээл, хүмүүсийн бичсэн дурсамж, дурдатгалд үндэслэн шинээр бичиж, С.А.Козины амьдарч байсан барилга биш, Т.Намсүрэнгийн амьдарч байсан барилга болохыг баталсан. Тус түүхэн дурсгалт барилгад шинээр музей байгуулах үзэл баримтлалыг боловсруулж, Т.Намнансүрэнгийн намтар, үйл хэрэгт холбогдох баримтын жагсаалтыг Үндэсний төв архиваас шүүн гаргаж, Нийслэл хүрээний түүхийг бичиж гаргасан. | |
| 1 | Музейн үйлчилгээний стандартыг үйлчилгээний албан байгууллагын стандарт, музейн үйлчилгээний нийтлэг арга хэмжээний дагуу Монголын үндэсний музей, Стандартчилал хэмжил зүйн газраас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч шинээр боловсруулж, төслийг музейн Захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлуулсан болно. | |
| 2.4. "Музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.4.1. | "Монгол Арт" галарейтэй хамтран "Хүрээ хийдийн монгол зураг" төсөл хэрэгжүүлж, "1870-аад оны Их хүрээ хотын монгол зураг" номын судалгааны ажлыг хийнэ. | - | Судалгааны бичвэрийн хуудасны тоо | 60 | 15 | "1870-аад оны Их хүрээ хотын монгол зураг" судалгааны ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв.<br>1.Монголын үндэсний архивт сууж, Их хүрээ зургийг бүтээсэн он цагт холбогдох баримтуудыг шүүн үзэв.<br>2.Зураач судлаачидтай уулзаж зургийн зохиомж, дүрслэлийн талаар зөвлөгөө авав.<br>3.Их хүрээ зурагт дүрслэгдсэн Хүрээний бүтэц, хэсэг болон сүм хийд, ордон, барилга, байшин зэрэг биет бүтэц, тэмдэгтүүдийн үүрэг, зориулалт, нэршлүүдийг тогтоож, тус бүрийн түүхийг бичих ажлыг эхлүүлээд байна.<br>4."Хүрээ хийдийн монгол төсөл"-ийн хүрээнд хийсэн судалгааны ажлын тайланг бичиж, Монгол Арт галарейд танилцуулав. | 100 |
| 2.4.2. | "Улаанбаатар мэдээ" сонины 1955-1990 оны дугаараас хотын түүхтэй холбогдолтой илтгэл, нийтлэлийг шүүн авч, баримтын эмхэтгэл гаргах ажлыг зохион байгуулна. | - | Хэвлүүлсэн эмхэтгэлийн тоо | | 1 | "Улаанбаатар мэдээ" сонины 1955-1960 онд холбогдох дугааруудаас хотын түүх болон хотын улс төр, нийгэм, соёл, аж ахуй, бүтээн байгуулалтын холбогдолтой 31 нийтлэл, өгүүлэл, илтгэлийг шүүн авч, номын эмхэтгэлд оруулахаар бэлтгэв. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.4.3. | Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол бичиг, гадаад хэлтэй үзмэрүүдийг хөрвүүлэн орчуулна. | - | Хөрвүүлэн орчуулсан баримтын тоо | |
| 2.4.4. | Улаанбаатар хотын иргэдийн дурсамжийн сан үүсгэж, иргэдээс дурсамж сурвалжлан авч баяжуулах ажлыг зохион байгуулна. | - | Баяжуулсан дурсамжийн тоо | 1 |
| 2.4.5 | Улаанбаатар хотын түүхийн чиглэлээр судалгаа хийж, эрдэм шинжилгээний нийтлэл бичиж хэвлүүлнэ. | - | Хэвлүүлсэн нийтлэлийн тоо | |

| | | |
|---|---|---|
| 20 | Сан хөмрөгт буй монгол бичиг, гадаад хэлтэй 20 үзмэрүүдийг хөрвүүлэн орчуулж, музейн арга зүйн зөвлөлийн хурлаар оруулахад бэлэн болгосон. | 100 |
| 1 | -Дурсамж сурвалжлан авах иргэдийн жагсаалтыг гаргасан.<br>-2022 оны 1 дүгээр улиралд сэтгүүлч, улс төрийн тоймч Д.Баярхүү гуайгаас "Хотжилт ба тэгшитгэл", "Коммунизмыг The BEATLES нураасан уу?" гэсэн хоёр хэсэгтэй, 17 хуудастай дурсамжийг бичүүлэн авсан.<br>-Нийслэлийн хөрөнгө оруулалтаар музейн засвар, тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл музейд хэрэгжиж байна. Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотын иргэдийн дурсамжийн сан үүсгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр шийдвэрлэгдэж бэлтгэл ажил хийгдэж байна. Уг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсны дараа иргэдийн дурсамжийг музейд видео бичлэг хэлбэрээр авах ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна. | 100 |
| 1 | МонголиаТүдэй цахим сэтгүүлийн 2022 оны 1 дүгээр улирлын "... Монголын цэнгэг агаар Ковидын дараах эм" дугаарт "Улаанбаатар хотын дурсгалт газрын гурван үеийн түүх: Сүхбаатарын талбай" нийтлэл, "Музейн товч танилцуулга" | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчилгааны баннер бэлтгэн өгч байршуулж, хотын түүх, музейн үйл ажиллагааг сурталчлав. 2022.05.10-нд МонголиаТүдэй сэтгүүлд “Улаанбаатар хотын түүхийн онцлог үйл явдлууд” нийтлэл бэлтгэн өгөв. | |
| 2.4.6. | Музейн үзмэрүүдэд тодорхойлолт бичиж, RCH программд бүртгэн оруулна. | - | Бүртгэсэн үзмэрийн тоо | - | 30 | Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт буй 30 үзмэрт тодорхойлолт бичиж, арга зүйн хурлаар оруулахад бэлэн болгосон. | 100 |
| 2.5. "Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.5.1. | Сан хөмрөг дэх үзмэрүүдээр сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж, нийтийн хүртээл болгон сурталчлах ажлыг зохион байгуулна. | - | Үзэсгэлэн гаргасан тоо | 2 | 2 | -Музейн үзэсгэлэнгийн түр танхимд 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр дэлгэгдсэн “Хуучин хот: Богдын хүрээ”, “Хуучин хот: Социалист Улаанбаатар” үзэсгэлэнгийн агуулгыг бэлтгэж, дэглэсэн. -“Олон улсын музейн өдөр”-ийг “Музейн хүч-нөлөө” уриан дор 05 сарын 18-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд уг өдөр сан хөмрөгиийн “ Хөрөг” сэдэвчилсэн үзэсгэлэн болон “Бидний баатар хот” боловсролын ажлыг зохион байгуулсан. -05 сарын 28-ний өдөр “Улаанбаатар хотын музейн нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулж нүүрэн дээр зураг зурах үйлчилгээ, уран бичлэгийн үзүүлбэр үйлчилгээ, хөрөг зураг зурах үзүүлбэр үйлчилгээ, ибру буюу усан дээр зураг зурах үйлчилгээ, “Бидний баатар хот” боловсролын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав. | |
| 2.5.2. | Музейн боловсролын ажлын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Боловсролын ажлын тоо Хамруулсан иргэдийн тоо | 4<br>160 | 7<br>300 | Музейн боловсролын ажлын дэд хөтөлбөрийн хүрээнд дараах боловсролын ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Нийслэлийн засаг даргын дэргэдэх хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын нийт 25 хүүхдэд "Миний мэдэх хот" боловсролын ажлыг зохион байгуулсан.<br>- Шинэ үе сургуулийн 2б ангийн 35 сурагчид "Би хотын иргэн" боловсролын ажлыг зохион байгуулсан.<br>- Нийслэлийн тээврийн газрын ажилчидын 16 хүүхэд багачуудад "Миний Улаанбаатар" боловсролын ажлыг зохион байгуулсан.<br>- Нийслэлийн засаг даргын дэргэдэх хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын ажилчид болон хүүхэд багачууд болох нийт 12 гэр бүлд "Төсөөллөө бүтээе" боловсролын ажлыг зохион байгуулсан.<br>- 05 сарын 18-ний өдөр болон 05 сарын 28-ний өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар хотын музейн нээлттэй өдөр"-т хүрэлцэн ирсэн хүүхэд багачууд, оюутан залуус, гэр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлд "Бидний баатар хот" боловсролын ажлыг зохион байгуулсан.<br>- Хан-уул дүүргийн 118-р сургуулийн 6 ангийн 32 сурагчид "Би хотын иргэн" боловсролын ажлыг зохион байгуулсан.<br>- Ус сувгийн удирдах газрын цэвэрлэх байгууламжийн алба, шугам ашиглалт засварын албын 30 гаруй ажилтанд Нийслэл хүрээний үеийн зурган дээр одоо үеийн барилга байгууламжийг олж байрлуулах боловсролын ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| 2.5.3. | Түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой сэдэвчилсэн үзэсгэлэнг цахим хэлбэрээр болон музейн байранд тогтмол зохион байгуулна. | - | Үзэсгэлэн гаргасан тоо | 1 | 1 | Нийслэлийн архивын газартай хамтран "Нийслэл хүрээ 110" баримт, гэрэл зураг, сан хөмрөгийн үзмэрийн сэдэвчилсэн үзэсгэлэнг Монголын Үндэсний музейн үзэсгэлэнгийн танхимд 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 02 дугаар сарын 24-ний өдөр хүртэл дэлгэн үзүүлж, олон нийтэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Уг үзэсгэлэнд музейгээс 14 үзмэр дэлгэгдэн тавигдсан. | 100 |
| 2.5.4. | Музейн цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийслэлийн түүхэн дурсгалт газар, барилга байгууламж, хөшөө дурсгал, гудамж талбайг | - | Сурталчилсан үйл ажиллагаа, дурсгалын тоо | 16 | 16 | -Музейн цахим хуудсанд Нийслэлийн түүхэн барилга байгууламж болон сүм хийдийн мэдээллийг комиск зургийн хамтаар нийт 8 удаа нийтэлсэн.<br>-02 сарын 12 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. | | | | | "Дамбадаржаа хийд"-ийн мэдээллийг комик зургийн хамт нийтэлсэн.<br>-02 сарын 14 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Мэгжид Жанрайсигийн дуган"-ны мэдээллийг комик зургийн хамтаар нийтэлсэн.<br>-02 сарын 17 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Богд хааны ногоон ордон"-ны мэдээллийг комик зургийн хамт нийтэлсэн.<br>-02 сарын 18 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Өндөр хоршоо" барилга байгууламжийн мэдээллийг комик зургийн хамт бэлтгэн оруулсан.<br>-03 сарын 24 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Гоожингийн өндөр" барилгын мэдээллийг комик зургийн хамтаар нийтэлсэн.<br>-03 сарын 25 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Монголорын хоёр давхар барилга"-ийн мэдээллийг комик зургийн хамтаар нийтэлсэн.<br>-04 сарын 06 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Чин ван Ханддоржийн өргөө"-ийн мэдээллийг комик зургийн хамт нийтэлсэн.<br>-04 сарын 08 өдөр Түүхэн дурсгалт барилга байгууламж болох "Оросын консул сайдын хоёр давхар барилга"-ийн мэдээллийг комик зургийн хамт нийтэлсэн. | |
| 2.6. "Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ" зорилтын хүрээнд: | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.1. | Улаанбаатар хотын түүхийн чиглэлээр цуврал бяцхан ном бүтээж, хүүхэд залуусын хүртээл болгоно. | 5,100.0 | Гаргасан номын тоо | - | 300 | Буддаг номын ерөнхий агуулгыг арга зүйч Э.Гэрэлмаа болон эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэнтэй ярилцаж, буддаг номонд хар зургаар зурагдах түүхэн барилга байгууламж, хөшөө дурсгал, сүм хийдийн нэрсийн жагсаалтыг гаргаж комиск зураач А.Аззаяад цахимаар илгээсэн. Түүх соёлын үл хөдлөх дурсгал болон музейн үзмэрүүдийн зураглал бүхий хар зургийн тайлбар, мэдээллийг Соёмбо Принтинг ХХК-ны дизайнерт бэлтгэн өгч хэвлүүлэх ажлыг эхлүүлсэн.<br>Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт өвийг хүүхэд багачуудад таниулах зорилгоор “Хотудай хотоор аялсан нь” буддаг номыг түүх соёлын үл хөдлөх дурсгал болон музейн үзмэрүүдийн зураглал бүхий бүтээж Соёмбо Принтинг ХХК- аар 300 ширхэг хэвлүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.2. | Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааг иргэдэд таниулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Брэнд дүр” бүтээж, музейгээс хэрэгжүүлэх сургалт, сурталчилгаанд ашиглана. | - | Бүтээсэн брэнд дүрийн тоо | - | 1 | Музейн “Брэнд дүр”-тэй болох зорилтын хүрээнд мэргэжилтэнүүдээс саналын хуудасаар дамжуулан музейн “Брэнд дүр”-ийн санал авч, түүнийхээ дагуу хэлэлцэж 2 дүрийн санааг гаргасан. Уг 2 дүрийн санаагаа комиск зураач А.Аззаяад цахимаар илгээсэн. Уг 2 дүрийн санаан дээр үндэслэн “Азука комикс”-той хамтран брэнд дүр бүтээх ажлыг зохион байгуулж, музейн мэргэжилтэнгүүдийн саналыг авч брэнд дүрийн нэрийг тогтож, сургалт сурталчилгаанд ашиглахад бэлэн болгосон. | 100 |
| 2.7. "Музей нь өөрийн цахим хуудастай байна. Цахим хуудсанд музейн эрхэм зорилго, байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, музейгээс зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэнгийн мэдээ мэдээлэл, санхүүжилт, төлбөр хураамж, санал, хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан эргэх холбоог хангаж ажиллана" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 2.7.1. | Музейгээс зохион байгуулсан арга хэмжээнүүдийг байгууллагын вэб хуудас, мэдээлийн сайт, сошиал сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэнэ. | | Цахим хуудаст оруулсан мэдээллийн тоо | 45 | 20 | Улаанбаатар хотын музейн инстаграм хаягт Хотын түүхийн хоёр минутанд, Улаанбаатар хотын үл хөдлөх түүхэн дурсгалт барилгууд болон Нийслэл хүрээ 110 жил үзэсгэлэнгийн мэдээ мэдээллийг стори болон пост хэлбэрээр оруулсан.<br>- 01-р сарын 12-ны өдөр “Зайсан толгой”-н талаар мэдээллийн пост оруулсан.<br>- 01-р сарын 14-ны өдөр “Богд хааны ордон”-ы талаар мэдээллийг пост хэлбэрээр пост оруулсан.<br>- 01-р сарын 15-ны өдөр “Төрийн шар ордон байсан газар”-ын талаар мэдээллийг пост оруулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 01-р сарын 17-ны талаарх “Богдын хүрэн ордны цогцолбороос үлдсэн барилгууд”-ыг талаар мэдээллийг оруулсан.<br>- 01-р сарын 18-ны өдөр “Гунгаадэжидлэн буюу Богдын Цагаан ордон”-ы талаар мэдээлэл оруулсан.<br>- 01-р сарын 26-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 1-ийг пост оруулсан.<br>- 01-р сарын 28-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 2-ыг пост оруулсан.<br>- 02-р сарын 07-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 3-ыг пост оруулсан.<br>- 02-р сарын 08-ны өдөр Нийслэл хүрээ 110 жил үзэсгэлэнгийн танилцуулагын пост оруулсан.<br>- 02-р сарын 10-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 4-ыг пост оруулсан.<br>- 02-р сарын 11-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 5-ыг пост оруулсан.<br>- 02-р сарын 15ны өдөр Мэгжид Жанрайсигийн сүмийн тухай пост оруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 02-р сарын 15-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 5-ыг пост оруулсан.<br>- 02-р сарын 17-ны өдөр Богд хааны ордон музейн цогцолборын тухай пост оруулсан.<br>- 02-р сарын 18-ны өдөр Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейн барилгын тухай пост оруулсан<br>- 02-р сарын 20-ны өдөр Нийслэл хүрээ 110 жил үзэсгэлэнгийн зурагуудаар reel хийж оруулсан.<br>- 02-р сарын 21-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 6-г пост оруулсан<br>- 02-р сарын 22-ны өдөр Нийслэл хүрээ 110 жил үзэсгэлэнгийн зургуудаас пост оруулсан.<br>- 03-р сарын 01ны өдөр Музейн гуравдугаар танхимд дэлгэгдсэн "Нийслэл хүрээ 110 жил " гэрэл зургийн үзэсгэлэнгийн постер зургийг оруулсан.<br>- 03-р сарын 08-ны өдөр олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөртэй холбогдуулан пост оруулсан.<br>- 03-р сарын 11-ны өдөр Хотын түүхийг хоёр минутанд цуврал бичлэгийн дугаар 8-ыг пост оруулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 03-р сарын 18-ны өдөр зэвсэгт хүчин байгуулагдсаны 101 жилийн “Монгол цэргийн өдөр”-тэй холбогдуулан пост оруулсан.<br>- 03-р сарын 24-ны өдөр Гоожингийн өндөрийн тухай пост оруулсан.<br>- 04 сарын 04-ний өдөр Музей зуны цагийн хуваарьт шилжсэн мэдээллийг бэлтгэн оруулсан.<br>- 04 сарын 13-ны өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчид Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаа болон нөхцөл байдалтай танилцсан мэдээллийг хуваалцсан.<br>- 05 сарын 18-ны өдөр зохион байгуулагдах “Улаанбаатар хотын музейн нээлттэй өдөр”-ийн постерийг нийтэлсэн.<br>- 05 сарын 18-ны өдөр “Хөрөг” сан хөмрөгийн сэдэвчилсэн үзэсгэлэнгийн үйл явцын мэдээлэл бэлтгэн нийтэлсэн.<br>- 05 сарын 28-ны өдөр зохион байгуулах “Улаанбаатар хотын музейн нээлттэй өдөр” арга хэмжээний постерийг нийтэлсэн.<br>- 05 сарын 28-нд зохион байгуулагдсан “Улаанбаатар хотын музейн нээлттэй өдөр”-ийн үйл явцын мэдээллийг бэлтгэн оруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 05 сарын 28 өдөр Мишээл экспод зохион байгуулагдсан "Ulaanbaatar travel expo 2022" үзэсгэлэнгийн мэдээллийг хуваалцсан.<br>Нийт 35 пост,бичлэг болон тэмдэглэлт өдрүүдэд зориулан 38 сториг интаграм, фэйсбүүкт оруулсан. | |
| 2.7.2. | Музейгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэн, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллана. | 3,060.00 | Төвлөрүүлсэн орлогын хэмжээ, мянган төгрөгөөр | 1,530 | 1,483.5 | Музейгээр хагас жилд том хүн 381, оюутан 179, хүүхэд 565, үнэ төлбөргүй 28, гадаад хүн 21 нийт 608 хүн үйлчлүүлсэн.<br>Музейн хамтран ажиллах бичгийн хүрээнд УСУГ-аас 271 хүн үйлчлүүсэн.<br>Музейн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 1,530.0 мян.төгрөг<br>Гүйцэтгэл 1,483.5 мян.төгрөг, орлогын төлөвлөгөө 96 % биелсэн үзүүлэлттэй. | 96 |
| 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд | | | | | | | |
| 3.1.Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх,санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлнэ. | - | Улирал бүр тайлан гаргаж хүргүүлсэн тоо | 4 | 2 | Музейн 2022 оны 3, 4, 5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орлогын болон өр авлагын дэлгэрэнгүй мэдээ, тайланг сар бүр гаргаж, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргэн хянуулан баталгаажуулсан.<br>Батлагдсан төсөв 2-р улиралд: 226,097.6 мян. төгрөг Үүнд:<br>1. Төсвөөс санхүүжих -224,567.6 мян.төгрөг<br>2. Үндсэн үйл ажиллагааны орлого- 1,530.0 мян.төгрөг<br>Гүйцэтгэл : 223,701.1 мянган төгрөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Төсвөөс урсгал санхүүжилт – 222,217.6 мян.төгрөг<br>2. Үндсэн үйл ажиллагааны орлого-1,483.5 мян.төгрөг<br>Нийт зарлагын дүн: 169,418.9 мян.төгрөг Үүнд:<br>1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил – 129,167.7 мян.төгрөг<br>2. НДШ /АО/ -16,275.5 мян.төгрөг<br>3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал -3,350.1 мян.төгрөг<br>4. Хангамж, бараа материалын зардал -3,343.1 мян.төгрөг<br>5. Багаж, техник хэрэгсэл худалдаж авсан зардал – 7,177.4 мян.төгрөг<br>6. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж - 1,091.7 мян.төгрөг<br>7. Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох – 2,600.0 мян.төгрөг<br>8. Газрын төлбөр -290.6 мян.төгрөг<br>9. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал – 5,122.8 мян.төгрөг<br>10. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал – 1,000.0 мян.төгрөг | |
| 3.1.2. | Үндсэн болон эргэлтийн хөрөнгийг бүрэн хаягжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. | - | Хаягжуулсан эд хөрөнгийн тоо | - | 81 | -Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй машин тоног төхөөрөмжийн 31 төрлийн 51 ширхэг, бусад материалын дансанд бүртгэлтэй 27 нэр төрлийн 30 ширхэг эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулж, бүх хөрөнгийг бүрэн хаягжуулах болон коджуулах ажлыг хийсэн.<br>-Улсын тооллогоор актлах саналтай хөрөнгийн жагсаалт Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1.Машин тоног төхөөрөмж – 18 төрлийн 26 ширхэг<br>21,373,225.00 төгрөг<br>2.Тавилга, эд хогшил -25 төрлийн 32 ширхэг 6,811,770.00 төгрөг<br>3.Түүх, соёлын дурсгалт зүйлсийн туслах хэрэглэгдэхүүн – 7 нэр төрлийн 15 ширхэг 2,942,000.00 төгрөг<br>Бүгд 50 нэр төрлийн 73 ширхэг 31,126,995 төгрөгийн | |
| 3.2.“Музейн албан хаагчдын эд хөрөнгө, бусад холбогдох материалаар тасралтгүй хангах, эд хөрөнгийн бүртгэлийг хөтлөх” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 3.2.1 | Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын үр дүнгээр илүүдэлтэй ашиглагдаагүй хөрөнгийн бүртгэл гаргах | | | | | Улсын тооллогоор актлах саналтай хөрөнгийн жагсаалт Үүнд:<br>1.Машин тоног төхөөрөмж – 18 төрлийн 26 ширхэг<br>21,373,225.00 төгрөг<br>2.Тавилга, эд хогшил -25 төрлийн 32 ширхэг 6,811,770.00 төгрөг<br>3.Түүх, соёлын дурсгалт зүйлсийн туслах хэрэглэгдэхүүн – 7 нэр төрлийн 15 ширхэг 2,942,000.00 төгрөг<br>Бүгд 50 нэр төрлийн 73 ширхэг 31,126,995 төгрөгийн хөрөнгүүдийг тооллогын комисс чанар байдлыг тодорхойлж, цаашид ашиглах боломжгүй гэж тодорхойлсон хөрөнгө тус бүрийн зургийг нь авч угаалган бэлтгэж,боловсруулсан. Цахим хуудсанд байршуулсан хөрөнгийн дүн мэдээ нь Нийслэлийн Өмчийн харилцааны газраар хянагдах шатандаа явж байна. Хянагдсаны дараа актлах хөрөнгийн саналаа хүргүүлэхээр бэлдэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | Байгууллагын үндсэн хөрөнгийн шинэчилсэн бүртгэл хөтлөх | | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | - | 1.Аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн 4,932,447.57 төгрөгийн дүнтэй хөрөнгийн бүртгэлийн дугаар давхацсан зөрчлийг арилган санхүүгийн программ дээр засч залруулсан. Үүнд:<br>- Барилга байгууламжийн бүртгэлд 4 талт хашаа нь хоёр өөр дүнгээр, дугаар ижил бүртгэлтэй байсан.<br>-Тавилга, эд хогшлын бүртгэлд бичгийн ширээ нь таван өөр төрлийн дүнтэй, бүртгэлийн дугаар ижил<br>- Машин, тоног төхөөрөмжийн бүртгэлд<br>- эйр кондишн хоёр өөр төрлийн дүнтэй, дугаар ижил<br>- утасны аппарат хоёр өөр төрлийн дүнтэй, дугаар ижил<br>-Принтер 135А хоёр өөр төрлийн дүнтэй, дугаар ижил байсан хөрөнгүүд багтана.<br>2.Тайлант хугацаанд номын фондын бүртгэлд бүхэл дүнгээр 2,395,810.00 төгрөгний ном байсныг нэг бүрчлэн бүртгэлд оруулсан. Нийт номын фондын бүртгэлд одоогоор 452 нэр төрлийн 617 ширхэг 4,662,308.00 төгрөгийн үнэ бүхий хөрөнгө байна. | 100 |
| 3.2.3 | Байгууллагын бараа материалын насжилтыг тодорхойлох, агуулахын өрөөний эд хөрөнгийн эмх цэгц, аюулгүй байдлыг хангах | | Насжилтын судалгаа | - | 1 | Бага үнэтэй түргэн элэгдэх материал:<br>2019 оны 101 нэр төрлийн 32,097,153.08 төгрөг<br>2020 оны 102 нэр төрлийн 33,490,599.08 төгрөг<br>2021 оны 181 нэр төрлийн 35,960,144.08 төгрөгний үнэ бүхий бараа материалын насжилтын | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалгааг боловсруулан, холбогдох мэргэжилтэнд илгээсэн.<br>-Байгууллагын агуулахын болон контейнер доторх эд хөрөнгө болон бусад зүйлсийг цэвэрлэж, эмх цэгцтэй болгон өөрчилж, үзмэрийн туслах хэрэглэгдэхүүн болон актлах саналтай хөрөнгө, бусад хөрөнгийг ялган байршуулж тавьсан. | |
| 3.2.4. | Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын ажлын зохион байгуулалтыг хууль тогтоомж, стандарт, журам заавРын дагуу хөтлөн явуулна. | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт | Зааврын дагуу хөтлөн явуулна | Зааврын дагуу хөтлөн явуулна | -Холбогдох хууль, тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийг жагсаалтад хуваарийн дагуу мэргэжилтнүүдээс архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журмын дагуу архивт хүлээлгэн өгсөн баримтуудыг үдэж, хавтаслан, данс бүртгэл хөтлөв. Үүнд: байнга хадгалах 32, түр хадгалах 35, тусгай төрлийн буюу гэрэл зургийн 6, 70 жил хадгалах 4, нийт 77 ширхэг баримтуудыг нягтлан шалгаж, бүртгэл үйлдэн, архивлав.<br>Тайлант хугацаанд байгууллагад ирсэн бичиг нийт 108 байна. Судалж байгаа 4 бичиг, хугацаа хоцорч шийдвэрлэсэн, зөрчилтэй бичиг байхгүй.<br>Тайлант хугацаанд музейн захирлын шийдвэрээр бусад байгууллагуудттай хамтран ажиллах, хүсэлт гаргах зэрэг нийт 86 албан бичиг явуулсан байна. Буцсан, зөрчилтэй бичиг байхгүй.<br>1,2 дугаар улиралд нийт 67 тушаал гарсан. А тушаал 40, Б тушаал 28 гарсан байна. Бүх ажилнуудын шуурхай хурлын тэмдэглэл 1, Музейн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл 4, өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл 1, Арга зүйн зөвлөлийн хурлын тэмдэглэл 1 тус тус хөтлөн явуулав.<br>-2021 оны А-53, Б-43 захирамжлалын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж архивлав. | |
| 3.2.5. | Музейн ажилтнуудын ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна. | - | Чанар, хариуцлага дээшлүүлэхэ эр зохион байгуулсан ажлын тоо | 4 | 2 | 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдөр мэргэжилтнүүдийн хагас жилийн тайланг дүгнэж баталгаажуулан Захирлын дэргэдэх захиргааны хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв. | 100 |
| 3.2.6. | Байгуулагын улирал, хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн гаргана. | - | Нэгтгэн гаргах тайлангийн тоо | 4 | 2 | Байгууллагын 1-р улирлын тайлан болон хагас жилийн тайланг мэргэжилтнүүдээс хүлээн авч дүгнэн нэгтгэж Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, НСУГ-т тус тус хүргүүлэв. | 100 |
| | Нийслэлээс сар тутам зохион байгуулагддаг "Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн"-с өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухайд нь хүргүүлнэ. | - | Тайлангийн тоо | - | 4 | Нийгмийн салбарын удирдах албан тушаалтнуудын шуурхай хуралдаанд өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн тайланг цаг хугацаанд гаргаж хариуцсан мэргэжилтэн болох Нийслэлийн засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Спорт, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 3.2.7. | Нийслэлээс 14 хоног тутамд байгууллагын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг цаг тухайд нь хүргүүлж тайлагнана. | - | Тайлангийн тоо | - | 12 | Нийслэлд 14 хоногийн тайлан мэдээг салбар хариуцсан Нийгмийн бодлогын хэлтэсийн Соёл урлаг, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэнд тогтмол цаг тухайд нь илгээж тайлагнаж байгаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд | | | | | | | |
| МУЗГ-ын 2009 оны 143 дугаар тогтоолын хавсралт Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт | | | | | | | |
| 4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал | | | | | | | |
| 4.1.1. | Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх | - | Хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн хоногийн тоо | 10 | 5 | Нийт 17 өргөдөл бүртгэж, холбогдох мэргэжилтнээр шийдвэрлүүлсэн байна. Үүнд:<br>Иргэн - Урлаг соёлын арга хэмжээний тухай 1-8,33%<br>Албан хаагч - Ажилд орох тухай 4-33,33%<br>Ээлжийн амралтын тухай 2-16,67%<br>Ажлаас чөлөөлөгдөх тухай 2-16,67%<br>Цалин хөлсний тухай 2-16,67%<br>Жирэмсний амралтын тухай 1-8,33%<br>Нийт 12-100%<br>2022 оны эхний хагас жилийн байдлаар музейд иргэд, албан хаагчдаас нийт 17 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Иргэн, албан хаагчдаас ирсэн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 21 цаг 50 минут байна. /Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайланг хавсаргав/ | 100 |
| 4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал | | | | | | | |
| 4.2.1. | Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх | - | Сул орон тооны мэдээллийг нээлттэй зарласан мэдээллийн хэрэгслийн тоо | 3 | 5 | Тайлант хугацаанд музейн дизайнер, архив, бичиг хэргийн ажилтан, боловсролын ажилтан, жижүүр, арга зүйч гэсэн 4 ажлын байрны зарыг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн хөдөлмөрийн бирж, музейн вэб сайт, “ Сайн уу Улаанбаатар минь фэйсбүүкээр 2022 оны 01 сарын 03-наас өдрөөс эхлэн 2022 оны 02 сарын 10-ны өдрийн хооронд байршуулан зарласан. 2022 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 01 сард жижүүр, боловсролын ажилтанг, 2 сард дизайнер , архив, бичиг хэргийн ажилтанг тус тус сонгон шалгаруулалт хийж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд авсан.<br>Мөн музейн арга зүйчийн ажлын байрны зарыг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн хөдөлмөрийн бирж, музейн вэб сайт, “Сайн уу Улаанбаатар минь” фэйсбүүкээр 2022 оны 05 сарын 03-наас өдрөөс байршуулан зарлаж байгаа боловч ажил горилогчийн анкет одоо хүртэл ирээгүй байна. | |
| 4.2.2. | “Хөдөлмөрийн хууль”-ийн шинэчилсэн найруулагатай холбоотой музейн үйл ажиллагаанд хөтлөгдөх дүрэм журмыг шинэчлэн боловсруулж батлуулах | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | Музейн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг Хөдөлмөрийн дотоод журмыг 10 бүлэг 8 хавсралттайгаар боловсруулж, хяналт хийж, 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр музейн захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн музейн захирлын А/22 тушаалаар батлуулав. | 100 |
| 4.2.3. | “Хөдөлмөрийн хууль”-ийн шинэчилсэн найруулагатай холбоотой хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж ажилтнуудтай гэрээг шинээр байгуулах | - | Шинээр байгуулсан хөдөлмөрийн гэрээний тоо | - | 18 | Шинэчилсэн хөдөлмөрийн тухай хуулийн 2022 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой музейн албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталгаажуулах ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 4.2.4. | Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж Төрийн албаны зөвлөлөөр батлуулах | - | Албан тушаалын тодорхойлолтын тоо | - | 15 | Албан тушаалын тодорхойлолт боловсруулалтын шатандаа явагдаж байгаа бөгөөд музейн захирлын 2022 оны А/25 дугаар тушаалаар ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэсгийг байгуулан ажиллаж боловсруулж дуусгав. | |
| 4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал | | | | | | | |
| 4.3.1. | Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг шилэн дансанд байршуулах | - | Хуулийн хугацаанд мэдээлсэн | - | 1 | Музейн 2-р улирлын 5,0 саяас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаанд нь байршуулсан. | 100 |
| 4.3.2. | Жилийн эцсийн санхүүгийн тайлан болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд байршуулах | - | Хуулийн хугацаанд мэдээлсэн | - | 1 | 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулсан. | 100 |
| 4.3.3. | 5 саяас дээш гүйлгээ гарсан тохиолдол бүрт шилэн дансанд байршуулах | | Хуулийн хугацаанд мэдээлсэн | | 2 | Музейн 1, 2-р улирлын 5,0 саяас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаанд нь байршуулсан. | 100 |
| 4.3.4 | Шилэн дансанд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон аудитаар баталгаажуулсан 2021 оны балансыг тус тус байршуулах | - | Хуулийн хугацаанд мэдээлсэн | - | 2 | Шилэн дансанд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ бусад өдөр тутмын мэдээ мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн байршуулсан.<br>1,2-р улиралд нийт 66 мэдээ, мэдээлэл хуулийн хугацаанд байршуулсан. | 100 |
| 5.“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 5.1 Мэдлэг, чадвараа дээшлүүлэх | | | | | | | |
| 5.1.1. | Нийслэлийн Төрийн сан, Нийслэлийн дотоод аудитын газар, Нийслэл | - | Сургалтын тоо | 2 | 3 | -Нийслэлийн ЗДТГ-ын 02 сарын 17-ны № 05/707 албан тоотын дагуу нийслэлийн ЗДТГазраас зохион | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэх Төрийн аудитын газар, Сангийн яамны Төрийн сангийн хэлтэс зэрэг мэргэжлийн дээд байгууллагуудын цахим болон уулзалт, семинар, сургалтанд тогтмол хамрагдах | | | | | байгуулсан цалингийн гүйлгээг цахимаар хийж, баталгаажуулах сургалтанд захирал П.Даваасүрэн, нягтлан бодогч Ж.Мөнхтуяа нар хамрагдсан.<br>-Америкийн Монгол судлалын төвөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Соёлын өв хэлэлцүүлэг: Монголын музейн цахимжуулалтын чиг хандлага" цахим сургалт, Олон Улсын Музейн зөвлөлөөс 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан "Музейн олон улсын цахим хурал: Залуучуудын илтгэл-Урлаг, соёл, өв (International Virtual Conference on Museums: Youth Presentation-Art, culture and heritage)" СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгээс 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан "Соёлын бодлого ба соёлын бүтээлч үйлдвэрлэл" сургалтуудад арга зүйч Э.Гэрэлмаа тус тус хамрагдав.<br>-Соёл Урлагийн Их сургуулиас зохион байгуулагдсан "Соёлын бодлого ба соёлын бүтээлч үйлдвэрлэл" эрдэм шинжилгээний хуралд цахимаар /ZOOM/ боловсролын ажилтан Б.Төгсжаргал хамрагдсан.<br>-Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан Архив, бичиг хэрэг хөтлөлт, стандартын сургалтад Захирал, Менежер, Архив бичиг хэргийн ажилтнууд тус тус хамрагдаж, бүх ажилтнуудад танилцуулав. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Үндэсний АУДИТ-н газар, Нийслэл дэх Төрийн АУДИТ-ын газараас зохион байгуулсан улсын тооллогын "Төрийн өмчийн тооллогын систем"-ийн сургалтад менежер, нягтлан бодогч нар хамрагдсан<br>-Соёлын Яам, Соёлын өвийн Үндэсний Төв, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагын Газраас хамтран зохион байгуулж байгаа "Соёлын өвийн хамгаалал" сэдэвт сургалтад Захирал, бүртгэл мэдээллийн санч, сан хөмрөгч нарыг хамруулсан<br>-Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв Төрийн албан хаагчийн ёс зүй сургалтад Менежер, Хүний нөөцийн мэргэжилтэн тус тус хамрагдав.<br>-Нийслэлийн Архивын Газраас зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн сургалтад Боловсролын ажилтан, Нярав, Үзмэр хянагч, Тайлбарлагч нарыг тус тус хамруулав.<br>-Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Үндэсний АУДИТ-н газар, Нийслэл дэх Төрийн АУДИТ-ын газараас зохион байгуулсан улсын тооллогын "Төрийн өмчийн тооллогын систем"-ийн сургалтад менежер, нягтлан бодогч нар хамрагдсан.<br>-Монголын Үндэсний музейгээс зохион байгуулсан "Музейн тайлбар чадавхжуулах сургалт"-нд тайлбарлагч, үзмэр хянагч, эрдэм | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээний ажилтан нар тус тус хамрагдсан. | |
| 5.1.2. | Музейн захиргаа, албан хаагчдаас цаг үеийн шинжтэй сургалт зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 1 | 4 | -Музейн менежер Б.Нарангэрэлийн “Хөдөлмөрийн дотоод журам” сэдэвт танхимийн сургалтанд хамрагдсан.<br>-Музейн арга зүйч Э.Гэрэлмаагийн “Музейн мэргэжилийн тухай ойлголт” болон “Музейн стандарт” сэдэвт танхимийн сургалт хамрагдсан.<br>-Музейн эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэнгийн “Монгол бичгийн хичээлийн анхан шат”-ны сургалтанд хамрагдсан.<br>-Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаярын “Музейд тайлбар хийх арга зүй”-н сургалтанд хамрагдсан. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 6. Нэмэлт ажлын биелэлт | | | |
| 6.1. | Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хариуцлагын гэрээг байгуулах | НЗДТГ | 2022 оны Улаанбаатар хотын музейн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж “Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нийслэлийн хэргэжүүлэгч агентлаг, харьяа байгууллагын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээг НЗДТГ-т хүргүүлж баталгаажуулан ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.02.05<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.2. | Нийслэлийн Засаг даргын А/08 дугаар захирамжын дагуу төсөвт байгууллагуудын 2021 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын хүрээнд бэлтгэл байдлыг хангаж ажиллах | Нийслэлийн Засаг даргын А/08 дугаар захирамж | Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа нийслэлийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх И.Баатархүү тэргүүтэй ажлын хэсэгт удирдамжийн дагуу 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021 оны биелэлтийг бэлтгэл ажлыг хангаж үнэлүүлсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.25<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.3. | Санамж бичиг байгуулан хамтран ажиллах, Нийслэлийн харьяа болон | Захирлын үүрэг даалгавар | -Архивын ерөнхий газар болон Юнеско-ийн Монголын үндэсний комисс-д хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллахыг хүссэн албан бичгийг боловсруулж илгээсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | хувийн хэвшил ТББ-тай хамтран ажиллах албан бичгийг хүргүүлэх | | Архивын ерөнхий газраас санамж бичгийг байгуулахгүйгээр хамтран ажиллаж болно гэсэн албан бичгийг хүлээн авсан. Юнеско-с хариу албан бичиг ирээгүй байна.<br>- Нийслэлийн 54 харьяа байгууллагатай музейгээ үзүүлэх орлого төвлөрүүлэлтийг сайжруулах хүрээнд хамтран ажиллах албан бичгийг хүргүүлсэн. Үүний үр дүнд Нийтийн тээврийн газар, Хүүхдийн ордон, Дотоод АУДИТ, Соёл урлагийн газар, СХД-н Цагдаагийн хэлтэс, Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн онцгой байдал, Агаар орчны бохирдолтой тэмцэх газар, Хүүхдийн урлан бүтээх төв, Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн цагдаагийн газар, УСУГ-с холбогдон хамтран ажиллахаа илэрхийлсэн. Одоогийн байдлаар УСУГ-с 271 хүн музейг үзсэн байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.03-03.30<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.4. | Хамтран ажиллах гэрээ байгуулах | Захирлын үүрэг даалгавар | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй ажилчин, албан хаагчид, ахмадуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж хамтран ажиллах, гэрээ байгуусан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.03-03.30<br>Биелэлтийн хувь: 100% |
| | Улаанбаатар хотын нийтийн төв номын сантай “Зөөврийн номын сангийн гэрээ” байгуулж, музейн бүх ажилтнуудад номын сангийн үнэмлэх нээж, гэрээр ном авч унших боломжийг бүрдүүлэх | Музейн захиргаа | Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сантай “Зөөврийн номын сангийн гэрээ” байгуулж, музейн бүх ажилтнуудад номын сангийн үнэмлэх нээж, зөөврийн номын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэв.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.04.01-04.05<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.5. | НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэсийн Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтэст төсөвийн зардал-Техникийн тодорхойлолтыг гаргаж өгөх | Музейн захиргаа | НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэсийн Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэнд 2022 оны нэн яаралтай тулгамдсан асуудал болох музейн цахилгааны болон барилгын урсгал засвар, ажилтнуудын албан хэрэгцээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, камерын системийн тоног төхөөрөмжийн төсөвийн задаргааг шинэчлэн Техникийн тодорхойлолтыг гаргаж хүргүүлсэн. Нийслэлийн худалдан авах |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ажиллагааны газараас тендер зарлах ажилд хамтран оролцсон (Нийт 219 сая орчим)<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.03-03.30<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.6. | “Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар”-аар барилгын дүгнэлт гаргуулах | Музейн захирал | 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас музейн барилгад эрсдийн үзлэг шинжилгээ хийж дүгнэлт гаргасан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.03-03.30<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.7. | Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх | Нийслэлийн өмчийн харилцааны газар | Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хүрээнд Өмч хамгаалах зөвлөлийн жилийн ажлын боловсруулсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаа. Тайлант хугацаанд нийт 12 ажил төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 88 оноо буюу бүрэн хангалттай гэсэн үнэлгээг авсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.03-03.21<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.8. | Өмч хамгаалах зөвлөлийн гишүүд болон журмыг шинэчлэх | Нийслэлийн өмчийн харилцааны газар | Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн 04 дүгээр хурлаар өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг шинэчилж захирлын А/ дугаар тушаалаар батлуулсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.03-03.21<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.9. | “Боловсролын ажилтны ажил хүлээлцэх” ажлын хэсгийг ахлаж ажиллах<br>Эхлэх/дуусах огноо: 2022.02.17 | Музейн захирлын тушаал | Музейн боловсролын ажилтны ажил хүлээлцэх ажлын хэсгийг ахлан ажиллаж, баримт, цахим баримт, эд хогшил, файлуудыг хүлээлгэн өгч хяналт тавьж ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.02.17<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.10. | “Архив, бичиг хэргийн ажилтны ажил хүлээлцэх” ажлыг хүлээлгэн өгөх<br>Эхлэх/дуусах огноо: 2022.02.17 | Музейн захирлын тушаал | Музейн архив, бичиг хэргийн ажилтны архивын баримт, цахим баримт, данс бүртгэл, бичиг хэргийн баримт, эд хогшил, файлуудыг хүлээлгэн өгч ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.02.17<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.11. | Сэргээн засварлалтаас үзмэр авчирах | СӨҮТөв | Музейн захирлын 2016 оны А/02 дугаар тушаалаар сан хөмрөгөөс сэргээн засварлалтад явуулсан UBM68.1 хувийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дугаартай “Монгол Зөвлөлтийн найрамдал” /модон сийлбэр/ үзмэр, сэргээн засварласан ажлын тайланг 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргал, боловсролын ажилтан Б.Төгсжаргал нарын бүрэлдэхүүнтэй очиж хүлээн авах ажилд оролцсон.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.02.21<br>Биелэлтийн хувь:100% |
| 6.12. | Байгууллагын гэрчилгээг шинэчилж УБЕГ-т захирлын өөрчилөлтийг бүртгүүлэх | Музейн захиргаа | Музейн захирал П.Даваасүрэн захирлыг УБЕГ-т бүртгүүлж гэрчилгээг шинэчилсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.13-2022.01.21<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.13. | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд албан хаагчдын мэдээллийг оруулах | - | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн систем 2022 оны 1 сард шинэчлэгдсэнтэй холбоотойгоор музейн албан хаагчдын мэдээллийг оруулах ажлыг хийсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.01.20-2022.02.17<br>Биелэлтийн хувь:100% |
| 6.14. | Нийслэлийн боловсролын газартай хамтран музейд интеграц хичээл зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах | Музейн захиргаа | 2022.02.18-нд Нийслэлийн боловсролын газартай хамтран Улаанбаатар хотын түүхийг ЕБС-ийн сурагчдад интеграц хичээлийн хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулахаар болов. Энэ ажлын хүрээнд тус хичээлийг музейд явуулах 39 дугаар сургуулийн монгол хэл, газарзүй, хөгжим, дүрслэх урлагийн 4 багшид музейг тайлбарлаж, музейгээс зохион байгуулдаг боловсролын ажлын талаар мэдээлэл өгөв.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.02.17-02.18<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.15. | Хэвлэл мэдээллийн байгууллагад музейн үйл ажиллагаа, хотын түүх, соёлын сэдвээр ярилцлага өгөх | Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр | -2022.01.21: Музейн үзүүллэгийн танхимд Нийслэл хүрээ – 110 жил ойн арга хэмжээний хүрээнд Босго фильмийн хийж буй “Монголын тусгаар тогтнол ба Нийслэл хүрээ” баримтат нэвтрүүлгийн зураг авалтад оролцож, Нийслэл хүрээний түүх, бүтэц зохион байгуулалт, хотын төвийн хэсэг, хадгалагдан үлдсэн дурсгалын талаар яриа өгөв.<br>-2022.01.29: Нийслэлийн төрийн захиргааны албан хаагчдын хотын түүхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Цэгц” медиа групптэй хамтран “Хуучин хот: Богдын хүрээ (1936-1921 он)”, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | “Хуучин хот: Социалист Улаанбаатар (1921-1990 он)” сэдэвт хоёр хичээлийг цахим хэлбэртэйгээр бэлтгэв.<br>-2022.02.25-нд “Дэвжих дэлхий” ТББ-аас хэрэгжүүлж буй Моод төслийн хүрээнд “Дулаанаа хадгалах моод” нэвтрүүлэгт оролцож Улаанбаатар хотын гэр хороолол, утааны талаар, “Чадах чадахаараа цэгцлэе” нэвтрүүлэгт оролцож Улаанбаатар хотын түгжрэлийн талаар тус тус ярилцлага өгөв.<br>-2022.03.07: Toim.mn сайтад музейн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлаар ярилцлага өгөв.<br>-2022.03.17: Монголын Үндэсний Олон нийтийн телевизэд Нийслэл хүрээнээс хадгалагдан үлдсэн түүх, архитектурын дурсгалт барилгуудын түүх, ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар ярилцлага өгөв.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.01.21-03.17<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.16. | Н.Жамбаагийн “Занабазар” баримлыг хувилан олшруулах санал бэлтгэж хүргүүлэх | НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс | Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй баримлач Н.Жамбаагийн 1955 онд бүтээсэн “Занабазар” баримлыг хувилан олшруулах саналыг боловсруулж, хоёр байгууллагаас үнийн санал авч, НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс рүү явуулав.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.02.25-03.01<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.17. | Улаанбаатар хотын түүх, соёлын чиглэлээр нийтлэл бэлтгэн хэвлүүлэх | Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр | -“World today media group” ХХК-иас эрхлэн гаргадаг “Mongolia Today” сэтгүүлийн “Улаанбаатар” буланд нийслэлийн түүх, соёлын холбогдолтой нийтлэл, контент бэлтгэн өгөхөөр тохиролцож, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр “Хамтран ажиллах гэрээ” байгуулав. 2022.03.09-нд Ворлд Түдэй медиа групп (World Today Media Group)-тэй Хамтран ажиллах гэрээний дагуу “Улаанбаатар хотын дурсгалт газрын гурван үе: Д.Сүхбаатарын талбай” нийтлэлийг бичиж, нийтлэл болон түүхэн гэрэл зургийг тайлбарын хамт хүргүүлсэн.<br>-2022.03.10-нд Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ТББ-аас эрхлэн гаргадаг “Жим-Аяллын хөтөч” сэтгүүлийн 2022 оны нэгдүгээр улирлын дугаарт “Рой Чапмэн Эндрюсийн экспедицийн гэрэл зурагт буусан “Нийслэл хүрээ” хот” сэдэвт |

| | | | |
|---|---|---|---|
| | | | нийтлэл хэвлүүлэхээр бэлтгэн явуулав. Уг нийтлэлд хавсралт 15 гэрэл зураг, тайлбарын хамт багтсан.<br>-Өндөөдөр сонинд "Урт цагааны барилга"-ын түүх, архитектур, өнөөгийн байдлын талаар ярилцлага өгөв. Уг ярилцлага Өнөөдөр сонины 2022.04.19-ны өдрийн №077 )7379( дугаарт О.Бат-Ундрахын бичсэн "200 гаруй жилийн түүхтэй Жуулчны гудамжаа гинжилсээр байх уу" нийтлэлд орж, хэвлэгдэв.<br>-Монголын үндэсний радиогийн "Дараагийн зогсоол" нэвтрүүлэгт зочноор оролцож, "Улаанбаатар хотын хөшөө баримал" сэдвээр ярилцлага өгч, Сүхбаатарын анхны хөшөө, Х.Чойбалсангийн хөшөө, Ажилчны алдар хөшөө гэсэн 3 хөшөө дурсгалын түүхийг онцлон ярив.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.04.01-06.30<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.18. | НЗДТГ-аас зохион байгуулах цаг үеийн арга хэмжээнд оролцоно. | НСУГ | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд хүүхэд багачуудад зориулан НЗДТГ, Нийслэлийн соёл урлагийн газар, Нийслэлийн Гэр бүл хүүхэд, залуучуудыг хөгжлийн газар тэргүүтэй Нийслэлийн холбогдох байгууллагаас зохион байгуулсан "Энх тунх- Мөнх тунх" нэртэй баярын арга хэмжээг зохион байгуулах ажилд оролцсон.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.06.01<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.19. | Соёлын яамны Соёл урлагийг дэмжих сангийн төслийн шалгаруулалтанд төсөл илгээнэ. | Музейн захиргаа | Соёлын яамны Соёл урлагийг дэмжих сангийн төслийн шалгаруулалтанд "Музейн брэнд дүрээр дамжуулан хотын түүхийг таниулах нь" сэдэвт төсөл бичиж, илгээх ажлыг зохион байгуулж, музейн мэргэжилтэнгүүдтэй хамтран төсөл боловсруулсан. Уг төслийн хоёрдугаар шат МҮОНР телевиз дээр зохион байгуулагдсан бөгөөд төслийн танилцуулга бүхий пресентаци бэлтгэж, бичлэгт орсон. Сүүлийн шатны хариуг хүлээж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.04.20-2022.06.30<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.20. | "Үндэсний номын баяр-2022" үзэсгэлэнд оролцоно. | Музейн захиргаа | "Үндэсний номын баяр-2022" үзэсгэлэнд бүх ажилтнуудаа оролцуулж, тусгай асарт музейгээс эрхлэн гаргасан номыг сурталчилах ажлыг хийж гүйцэтгэсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Эхэлсэн, дууссан огноо: 2022.05.20<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.21. | Бүх нийтээр мод тарих хөдөлгөөнд оролцоно. | НЗДТГ | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих үндэсний өдөр “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-д 10 мод тарьсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.05.07<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.22. | Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцох | НЗДТГ | Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан их цэвэрлэгээнд байгуулгын ойр орчмын 50м газар болон гаднах орчныг цэвэрлэж баталгаажуулан тайланг холбогдох ажилтанд хүргүүлсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2022.04.22<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.23. | Бусад зохион байгуулалттай ажил | Музейн захиргаа | -2022.01.06: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Баатархүүгийн зарлан хуралдуулсан Дамбадаржаа хийдийг хадгалж хамгаалах талаарх хуралд сууж, саналаа хэлэв.<br><br>-2022.01.06: Нийслэлийн Засаг даргын зөвлөх Мөнх-Эрдэнийн зарлан хуралдуулсан Ерөнхий сайд Намнансүрэнгийн амьдарч байсан Гоожингийн өндөр хэмээх түүхэн дурсгалт барилгыг хадгалж хамгаалах талаар хуралд сууж саналаа хэлэв.<br><br>-2022.01.10: Нийслэлийн архивын газраас зарласан “Нийслэл хүрээ-110 жил”-ийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх хуралд оролцож, музейгээс хамтран хэрэгжүүлэх саналыг хэлж, ойн арга хэмжээний төсвийг боловсруулан гаргаж өгөв.<br>-2022.01.11: Нийслэл хүрээ-110 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэн арга хэмжээний хүрээнд “Монголын тусгаар тогтнол ба Нийслэл хүрээ” сэдэвт баримтат нэвтрүүлгийг Босго фильм хийхээр болж, тус студийн Ган-Очиртой Нийслэлийн архивын газрын гэрээт эрдэм шинжилгээний ажилтан доктор Мөнхбаяртай хамт уулзаж, нэвтрүүлэгт оролцох хүн, зураг авах газар, нэвтрүүлгийн сэдэв, агуулгын талаар ярилцаж, тохиров. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | -2022.01.13: Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэсийн дарга М.Гансэлэмд Д.Сүхбаатарын талбайн өмнөх Төв цэцэрлэгт хүрээлэнгийн товч түүхийг бичиж явуулав.<br>-2022.01.14: Монгол Ардын намын удирдах зөвлөлд Ардын хувьсгалын түүхэнд холбогдох “Намын Төв хороо, Ардын Түр Засгийн газар байрлаж байсан байшин”, “Консулын дэнжийн нууц бүлгэм байрлаж байсан барилга” хэмээх түүхэн дурсгалт хоёр барилгыг сэргээн засварлах, тохижуулах саналыг боловсруулж, албан бичгээр хүргүүлэв.<br>-2022.01.25: Музейн дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах талаар санал гаргаж, ажлын хэсэгт орж ажиллав.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.01.06-01.25<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.24. | Дадлага ажил удирдах | Музейн захиргаа | МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Аялал жуулчлалын ангийн 3 дугаар ангийн оюутан М.Мөнх-Очир, О.Саруулсайхан, Г.Буянтогтох нарыг музейн дадлага ажил хийх нөхцөл боломжоор хангаж, дадлага ажлыг удирдав.<br>Эхэлсэн, дууссан огноо:<br>2022.03.20-04.05<br>Биелэлтийн хувь: 100 |
| 6.25. | Улаанбаатар хотын түүх, соёлын чиглэлээр лекц, хичээл зааж, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах<br><br>Эхлэх / дуусах огноо:<br>2022.01.20 / 2022.03.05 | Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр | -ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын “Нийслэл хүрээ 110 – ШУТИС Монголын түүхийн 7 хоног” арга хэмжээнд эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр оролцож, 2022.04.26-ны өдөр ШУТИС-ийн 210 оюутанд “Улаанбаатар хотын түүх: Үүсэл, хот байгуулал, өв соёл” сэдвээр лекц уншиж, хотын түүх, соёлыг залуust сурталчлан таниулав.<br>-2022.05.04-нд Аялал жуулчлалын ур чадварын сургуулийн 7 хөтчид “Улаанбаатар хотын түүх” сэдэвт хичээл заав.<br>-2022.05.13-нд Америкийн монгол судлалын төвд Монгол Улстай танилцахаар ирсэн Америк Улсын ЕБС-ийн 25 сурагчдад музейн үзүүллэгийн танхимаар дамжуулан |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Улаанбаатар хотын түүхийн хичээлийг зааж, хотын түүх, соёлыг сурталчлав.<br>-2022.05.24-нд Олон Улсын музейн өдрийг тохиолдуулан Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейгээс тайлбарлагч, боловсролын ажилтан нарт зориулсан лекцийн зочин илтгэгчээр эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр оролцож “Тайлбарлагч гэж хэн бэ?, Боловсролын ажилтан гэж хэн бэ?” сэдвээр лекц уншив. Уг лекцэд Чингис хаан музей, Дүрслэх урлагийн музей, Байгалийн түүхийн музей, Богд хааны ордон, Улаанбаатар хотын музейн тайлбарлагч, боловсролын ажилтан 13 хүн хамрагдсан.<br>-2022.05.25-нд Аялал жуулчлалын ур чадварын сургуулийн 12 хөтчид “Улаанбаатар хотын түүх” сэдэвт 3.5 цагийн хичээл заав.<br>-2022.06.11-нд Гайд төвөөс зохион байгуулсан хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалтад хамрагдсан 40 суралцагчдад “Улаанбаатар хотын түүх” сэдвээр лекц уншив.<br>-2022.06.16-нд “Оюутан цагдаа” хөтөлбөрт хамрагдаж буй 120 залуust “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ?”, “Улаанбаатар хотын гудамж талбайн нэрийн тухай” сэдвээр Нийслэлийн иргэний танхимд лекц уншив.<br>Тайлант хугацаанд 7 лекц, хичээл уншиж, 427 хүн хамрагдав.<br>**Эхэлсэн, дууссан огноо:**<br>2022.04.01-06.30<br>**Биелэлтийн хувь:** 100 |

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ П.ДАВААСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
МЕНЕЖЕР Б.НАРАНГЭРЭЛ